



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/304

Мөрөн сум

Хүүхдийн цэцэрлэгт бүлэг нэмж  
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны газрын дүгнэлтийн дагуу Баянзүрх сумын хүүхдийн цэцэрлэгт хоёр бүлэг шинээр нэмж ажиллуулсугай.

2. Дээрх цэцэрлэгт бүлэг нэмсэнтэй холбогдон гарах зардлыг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ц.Ганзориг)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Ч.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН